



**ХЭНТИЙ АЙМАГ  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

23119 Чингис хот, Хэнтий аймаг,  
Утас/Факс: 70-56-24-12  
E-mail: infoazdtg@khentii.gov.mn

ГАЛШАР СУМЫН ЗАСАГ ДАРГА  
Ө.САРАНТУЯА ТАНАА

2022.05.03 № 7/970.  
танай -ны № -т

Дүгнэлт, зөвлөмж хүргүүлэх тухай

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын баталсан удирдамжийн дагуу 2022 оны 04 дугаар сарын 20-ны өдөр тус сумын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөн туслах үйл ажиллагаа хийсэн дүнг удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулж дараах дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

**Дүгнэлт:** Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийг хяналтад аваагүйн улмаас аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагууд руу хууль, тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн биелэлт хугацаандаа явсан эсэх, ямар биелэлт яваад хэрхэн үнэлэгдэж байгааг мэддэггүй. Байгууллагын болон төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний уялдааг хангаж, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг зөв тодорхойлох, сумын Засаг даргын үйл ажиллагааны төлөвлөгөөний арга хэмжээнүүдийг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах шаардлагатай гэж дүгнэж байна.

**Зөвлөмж:**

1. Хууль тогтоомж, тогтоол, шийдвэр болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн холбогдох заалтуудыг жил бүр жагсаалт гарган шинэчлэн батлуулж, тайланд хяналт тавьж ажиллах

2. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг зөв тодорхойлох, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний арга хэмжээнүүдийг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд бүрэн тусгах, төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд уялдуулан зорилтыг арга хэмжээ болгон нарийвчлан задалж боловсруулах

3. Аймгийн Засаг даргын 2021 оны А/105 дугаар захирамжийн хавсралтаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмыг хэрэгжүүлэх аргачлал”-ын

2.

3 дугаар зүйлийн 3.3.1-д заасны дагуу төсөвт байгууллагуудад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангаж ажиллах

4. Үнэлгээний төхөөрөмжийн журмын хэрэгжилтийг хангаж үйлчилгээ авсан үйлчлүүлэгчээр үнэлүүлж, АХХ-ын журамд заасны дагуу шаардлага хангасан тайлан, мэдээг үнэн бодитой гаргаж сар бүрийн 25-ны дотор Төрийн захиргааны удирдлагын хэлтэст хүргүүлэх

5. Удирдлагууд болон нийт албан хаагчид [www.erp.e-mongolia.mn](http://www.erp.e-mongolia.mn) системийг тогтмол ашиглаж, удирдлагууд хяналт тавьж хэвших, босоо удирдлагатай албан хаагчдыг тухайн сумын Засаг даргын Тамгын газарт эрх үүсгэх, админ эрхтэй албан хаагч шинээр орсон ажилтан албан хаагчдыг системд бүртгэх, албан хаагчдын системд хандах эрхийг бүрэн гүйцэд, зөв тохируулах, системээс автоматаар үүсдэг зөрчлийг гаргахгүй байх

6. Сумын мэдээлэл хүргэдэг хуудсуудыг идэвхтэй ажиллуулж тогтмол мэдээлэл оруулдаг байх, аймгийн Засаг даргын Тамгын газрын пейж хуудсыг дагаж мэдээллийг сумын цахим хуудсуудаар хуваалцдаг байх, байгууллагын мэдээллийн самбарын мэдээллийг тогтмол шинэчлэх

Зөвлөмжийн дагуу гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган биелэлтийг 2022 оны 05 сарын 13-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ  
ХЭЛТСИЙН ДАРГА, Ц.ГАНЧИМЭГ

